

ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ҮР ДҮНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

/THE COMPARISON OF RESULTS OF JOB PERFORMANCE ON EXPERT/

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

ДХИС-ийн докторант, ШШҮХ-ийн ахлах шинжээч,
цагдаагийн ахмад

ERDENEJARGAL Munkhjargal

Ph.D student of the University of Internal Affairs, police captain,
A senior forensic expert at National Institute of Forensic Science

Г.ГАНХҮЛЭГ

ДХИС-ийн докторант, ШШҮХ-ийн ахлах шинжээч,
цагдаагийн хошууч

GANKHULEG Ganbaatar

Ph.D student of the University of Internal Affairs, police captain,
A senior forensic expert at National Institute of Forensic Science

Хураангуй. Энэхүү илтгэлээр Шүүхийн шинжилгээний байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн “Байгууллагын ажил үйлчилгээний чанарын түвшинг нэмэгдүүлж, цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх”, “Сургалтын чанарыг сайжруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг ахиулах” гэсэн зорилтод тусгагдсан үндсэн агуулгыг дэмжин, криминалистикийн шинжээчийн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, боловсронгуй болгох талаар тодорхой санал дэвшүүлэхийг зорьсон болно.

Судлаачдад криминалистикийн шинжээчээр ажилласан туршлага, шинжээчдийн дунд хийсэн ярилцлагын үр дүнд “шинжилгээ хийж, дүгнэлт гаргах болон гэмт хэргийн газрын үзлэг хийхэд нөлөөлөх хүчин зүйлс нь харилцан адилгүй байдаг” гэсэн төсөөлөл бий болсон. Иймээс бид чанарын судалгааны SMART PLS-3.0 програм ашиглан хэмжил зүйн, хамаарлын, олон хүчин зүйлийн, замын шинжилгээ хийхдээ Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын хүрээнд тухайн хүчин зүйлийн хувьсагчид шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад болон шинжээч, мэргэжилтэн хэргийн газрын үзлэг хийхэд үзүүлэх нөлөөллийг тус тусад нь судалж, хооронд нь харьцуулан үр дүнг нэгтгэлээ.

Шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааны чиглэлээр хийсэн судалгаанд 71 криминалистикийн шинжээч цахимаар хамрагдсан. Харин гэмт хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцох чиглэлээр хийсэн судалгаанд 116 криминалистикийн шинжээч, мэргэжилтэн цахимаар хамрагдсан.

Түлхүүр үг: мэргэжлийн ур чадвар, техник, тоног төхөөрөмж, сэтгэл ханамж, сургалт, хөгжил, зан төлөв, оролцоо, мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил, орчин, нөхцөл байдал

Abstract. This paper aims to try for implementing the main objective such as the goal of National Forensic Science Institute of Mongolia for “Improving quality's level of the work and service of the organization, implementing digital innovation” and “enhancing the training's quality, improving the knowledge and skill of the employee”.

As a result of the researcher's experience working as a forensic expert and interviews with forensic experts, there was a imagination that “factors influencing of examination and crime scene investigation are different”.

Therefore, in our qualitative research, we analyzed and conducted the influence of the impacts on the job performance which is called forensic examination and crime scene investigation within a employee in the National Institute of Forensic Science organization by SMART PLS 3.0 software. To accomplish the determined aim of our study, the forensic examination's research collected data through a structured questionnaire from 71 forensic experts who work in the National Forensic Science Institute of Mongolia and other experts. And the crime scene investigation's research collected data through a structured questionnaire from 116 forensic experts and specialist.

Keywords: professional skills, technique and equipment, satisfaction, training and development, behavior, engagement, knowledge, skills, attitude and maturity, environment and situation.

Удиртгал

Судалгааны ажлын үндэслэл: Криминалистикийн шинжээчийн ажлын гүйцэтгэлийн гол үр дүн болох дүгнэлт нь шинжлэх ухаан, хууль зүй, техник, хүний хүчин зүйлийн шалгуурыг хангасан нотлох баримт болоход нөлөөлөх хүчин зүйлсийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах зайлшгүй шаардлага тулгарч байгаа нь энэхүү судалгааг хийх практик үндэслэл болж байна.

Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын зорилт 7.4-ийн 4 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагын техник, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадамж дээшилсэн байна”, “Салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлэх” талаа тус тус тусгасан нь энэхүү илтгэлийн эрх зүйн үндэслэл болж байна.

Судалгааны объект: Шүүхийн шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчийн ажлын гүйцэтгэл.

Судалгааны зорилго, зорилт: Шүүхийн шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчийн ажлын гүйцэтгэлд ямар, ямар хүчин зүйлс нөлөөлж буйг шинжилгээ болон хэргийн газрын үзлэг чиглэлээр тус, тусад нь тодорхойлох, тухайн хувьсагчид ажлын гүйцэтгэлд хэрхэн нөлөөлөх, ямар хамааралтайг судалсны үндсэн дээр криминалистикийн шинжээчийн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, шинжилгээний

арга зүйг өргөжүүлэх, боловсронгуй болгоход оршино.

Сэдвийн судлагдсан байдал: М.Түмэннаст, Ц.Баясгалан, Б.Лхагвасүрэн нар гарын үсгийн шинжээчдийн ажлын гүйцэтгэлд ур чадвар, хандлага, цагийн менежмент, техник тоног төхөөрөмж, ажлын туршлага зэрэг нь хэрхэн нөлөөлж байгааг судалсан.¹

Ц.Баясгалан, Б.Номин нар бизнес эрхлэгчдийн мэргэжлийн ур чадвар, хандлага, ажлын туршлага нь ажлын гүйцэтгэлд үзүүлэх нөлөөлөлд дүн шинжилгээ хийсэн. Тэд судалгаагаараа 4 таамаглалд дүн шинжилгээ хийсэн бөгөөд үүнээс нэг таамаглал батлагдан, гурван таамаглал батлагдаагүй талаар тайлбарласан.²

Менежментийн шинжлэх ухааны чиглэлээр буюу ажлын гүйцэтгэл түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг байгууллагын онцлогт тулгуурлан тал бүрээс нь судалсан эрдэм шинжилгээний бүтээл олон улсад нэлээдгүй олон байна. Тухайлбал: Pandey, J. (2019), "Factors affecting job performance: an integrative review of literature", *Management Research Review*, Hassan M. E. Aboazoum, U. Nimran, M. A. Musadieq. (2015), *Analysis Factors Affecting Employees Job Performance in Libya*, Maureen Mwaiko. (2013), *Factors affecting employee performance Assessment in the education sector in Tanzania: a Case study of Pugu secondary school*, Li Wang, Kunhui Ye, Yu Liu, Wenjing Wang (2022) *Factors affecting expert performance in bid evaluation: An integrated approach*, Tengpongsthorn, W. (2016) *Factors affecting the effectiveness of police performance in Metropolitan Police Bureau* гэх мэт.

¹ M.Tumennast, Ts.Bayasgalan, B.Lkhagvasuren, "The impacts of skills, attitude, time management, technical equipment and work experience on work performance: the case of national forensic science institute of mongolia", *International Journal of Innovation Scientific Research and*

Review, May 2022, Vol. 04, Issue, 05, pp.2731-2735.

² Ts.Bayasgalan, B.Nomin, "The Impacts of Professional Skills, Attitude, Time Management and Work Experience on Job Performance: The Case of Mongolia", *Advances in Social Sciences Research Journal*, 2022, Vol. 9(7), 103-114.

Судалгааны ажлын шинэлэг тал:

Манай улсын хувьд төрийн байгууллагын алба хаагчдын ажлын гүйцэтгэлийн талаар судалсан судалгааны бүтээлүүд байгаа хэдий ч Шүүхийн шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчийн ажлын гүйцэтгэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Smart PLS” програм ашиглан цогц судалгаа хийж, шинжилгээ болон гэмт хэргийн газрын үзлэг хийхэд нөлөөлж буй хүчин зүйлсэд харьцуулалт хийж байгаа нь энэхүү судалгааны ажлын шинэлэг тал юм.

Судалгааны арга зүй: Судалгааны таамаглал, загварыг бүтцийн тэгшитгэлийн загварт суурилсан SmartPLS 3.0 програмыг ашигласан ба PLS-SEM нь хувьсагч хоорондын таамаглалыг харуулах, загварчлалыг тооцоолоход хамгийн чухал шинжилгээний арга юм. Судалгаанд дэвшүүлсэн таамаглалыг шалгахдаа хэмжилзүйн болон бүтцийн загварын шинжилгээний аргуудыг хэрэглэсэн.

Үндсэн хэсэг

Гүйцэтгэл гэдэг нь тухайн хүн болон түүний ажлын шаардлага, сургалт, хөгжил, зан үйлийн хоорондын харилцан үйлчлэлийн хэмжигдэхүйц үр дүн юм.³ Ажлын гүйцэтгэл нь микро түвшин (хувь хүн), мезо түвшин (бүлэг) болон макро түвшин (байгууллага) гэсэн гурван түвшний үр дүнд нөлөөлдөг чухал хувьсагч юм. Ажлын орчин, удирдлагын дэмжлэг нь ажлын гүйцэтгэлд хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг (шууд ба шууд бус) бол дасан зохицох чадвар, дотоод сэдэл нь ажлын гүйцэтгэлд шууд нөлөөлдөг болохыг харуулж байна.⁴

Байгууллагын зорилго нь гүйцэтгэлийг өндөр байлгаж, үр ашгийг нэмэгдүүлэхэд оршдог бөгөөд гүйцэтгэлийг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Үүрэг даалгаврын биелэгдсэн түвшинг гүйцэтгэл гэнэ.

- Аливаа үйлдлийн болон үйл ажиллагааны үйл явц, арга хэлбэр юм.

- Гүйцэтгэл нь мэдлэг эзэмшсэнээр мэдлэгийг хэрэглэснээр аливаа ажлыг амжилттайгаар хийж гүйцэтгэх үйлдэл юм.

Дээрх тодорхойлолтуудыг нэгтгэж үзвэл ажлын гүйцэтгэл гэдэг нь мэдлэгээ ашиглан үүрэг даалгаврыг биелүүлэх үйл ажиллагаа, түүний арга хэлбэр юм гэж ойлгож болохоор байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын хувьд эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд криминалистикийн шинжээч, мэргэжилтэн хуульд заасан үүргийн хүрээнд шинжилгээ хийж дүгнэлт гаргах, гэмт хэргийн газрын үзлэг хийж ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлж байгаа нь ажлын гүйцэтгэл юм.

Тиймээс Шүүхийн шинжилгээний байгууллагын хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд ямар хүчин зүйл шууд хамааралтайгаар нөлөөлж байгааг илрүүлэх, нийгмийн шинжлэх ухаан болох менежментийн онол арга зүйн ажлын гүйцэтгэлийн суурь онол, эрдэмтэн судлаачдын судалгааны үр дүнд тулгуурлан энэхүү судалгааны ажлын таамаглалуудыг дэвшүүлсэн. Дээрх судалгааны ажлын онол, онолын суурь ойлголтод нөлөөлж байгаа хүчин зүйлийн уялдаа холбоог дэмжин судалж, судалгааны ажлын таамаглалд үндэслэн загварыг дараах байдлаар гаргасан.

³

<https://trainingindustry.com/articles/performance-management>

⁴ Pandey, J. (2019), "Factors affecting job performance: an integrative review of literature", *Management Research Review*, Vol. 42 No. 2, pp. 263-289.


Хүснэгт №1. Ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хувьсагчдын хамаарал



Судалгааны боловсруулалт

Криминалистикийн шинжилгээ хийхэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаанд 71 шинжээч, хэргийн газрын үзлэг хийхэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаанд 116 шинжээч, мэргэжилтнийг тус тус хамруулсан ба чанарын судалгаагаар, хүчин зүйлийн шинжилгээ, хэмжил зүйн шинжилгээ, хамаарлын шинжилгээ, замын шинжилгээний боловсруулалт хийн үр дүнг гаргасан.

Хүснэгт№2. Хэмжил зүйн шинжилгээний үр дүнгийн харьцуулалт /Алгоритм/



Хэмжил зүйн шинжилгээний үр дүн нь энэхүү судалгааны ажлын хамгийн чухал хэсэг бөгөөд судалгааны үр дүнг боловсруулах, харьцуулан шинжлэх, бататгах, дүгнэх хэсэг юм. Уг шинжилгээгээр далд хувьсагч бүр ажлын гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж байгааг харуулах ба хүчин зүйл тус бүрийн үр дүнг гаргасан болно. Кронпа альфа буюу тогтвортой байдал нь далд хувьсагчдын багц үзүүлэлт хоорондоо хэрхэн уялдаатай байгааг илэрхийлнэ.

Шинжилгээ хийхэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгааны хэмжил зүйн шинжилгээнээс харахад, мэргэжлийн үр чадвар хувьсагч нь **0.345-0.861** хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга **0.815**, найдвартай байдлын утга **0.850**, дундаж утгын үр дүн **0.427** тус тус гарсан. Эндээс мэргэжлийн үр чадвар дундажаас бага үзүүлэлттэй, Асуулт-2: “Шинжилгээний арга зүйн ашиглалт” **0.345**, Асуулт-3: “Дүгнэлт бичих” **0.661**, Асуулт-4: “Техник

хэрэгсэл ашиглалт” **0.562**, Асуулт-5: “Нарийвчлан ажиглах байдал” **0.611**, Асуулт-6: “Шүүмжлэлт сэтгэлгээ” **0.647**, Асуулт-7: “Мэргэжлийн туршлага” **0.661** ач холбогдлоор нь үнэлэх асуултын хариултын үр дүнгүүд хүлээлтээс бага түвшинд байгаа нь анхаарал татаж байна (Хүснэгт №3).

Хүснэгт №3. Хэмжил зүйн шинжилгээ (мэргэжлийн үр чадвар)

Хувьсагч	Далд хувьсагч	Хэмжил зүйн утга	Кронбах альфа утга	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Мэргэжлийн үр чадвар	prf.sk-1	0.759	0.815	0.850	0.427
	prf.sk-2	0.345			
	prf.sk-3	0.661			
	prf.sk-4	0.562			
	prf.sk-5	0.611			
	prf.sk-6	0.647			
	prf.sk-7	0.661			
	prf.sk-8	0.861			

Хэмжил зүйн шинжилгээнээс харахад, техник, тоног төхөөрөмж хувьсагч нь **0.630-0.860** хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга **0.905**, найдвартай байдлын утга **0.924**, дундаж утгын үр дүн **0.606** тус тус гарсан. Эндээс техник, тоног төхөөрөмж дундажаас бага

үзүүлэлттэй, Асуулт-2: “Техник, тоног төхөөрөмжийн ашиглалт” **0.650**, Асуулт-8: “Техник, тоног төхөөрөмжийн стандартчлал” **0.630** ач холбогдлоор нь үнэлэх асуултын хариултын үр дүнгүүд хүлээлтээс бага түвшинд байгаа нь анхаарал татаж байна (Хүснэгт №4).

Хүснэгт №4. Хэмжил зүйн шинжилгээ (техник, тоног төхөөрөмж)

Хувьсагч	Далд хувьсагч	Хэмжил зүйн утга	Кронбах альфа утга	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Техник, тоног төхөөрөмж	tchn-1	0.782	0.905	0.924	0.606
	tchn-2	0.650			
	tchn-3	0.857			
	tchn-4	0.860			
	tchn-5	0.794			
	tchn-6	0.790			
	tchn-7	0.832			
	tchn-8	0.630			

Хэмжил зүйн шинжилгээнээс харахад, сэтгэл ханамж хувьсагч нь **0.437-0.906** хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга **0.849**, найдвартай байдлын утга **0.880**, дундаж утгын үр дүн **0.495** тус тус гарсан. Эндээс сэтгэл ханамж дундажаас бага үзүүлэлттэй, Асуулт-1: “Шинжилгээний үр дүн” **0.655**, Асуулт-2:

“Ажлын орчин” **0.551**, Асуулт-6: “Гүйцэтгэлийн үнэлгээ” **0.525**, Асуулт-7: “Гүйцэтгэлийн хөлс” **0.606**, Асуулт-8: “Хөнгөлөлт, урамшуулал” **0.437** нөлөөллөөр нь үнэлэх асуултын хариултын үр дүнгүүд хүлээлтээс бага түвшинд байгаа нь анхаарал татаж байна (Хүснэгт №5).

Хүснэгт №5. Хэмжил зүйн шинжилгээ (сэтгэл ханамж)

Хувьсагч	Далд хувьсагч	Хэмжил зүйн утга	Кронбах альфа утга	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Сэтгэл ханамж	stsn-1	0.655	0.849	0.880	0.495
	stsn-2	0.551			
	stsn-3	0.904			

	stsn-4	0.906			
	stsn-5	0.869			
	stsn-6	0.525			
	stsn-7	0.606			
	stsn-8	0.437			

Хэмжил зүйн шинжилгээнээс харахад, сургалт, хөгжил хувьсагч нь **0.467-0.887** хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга **0.907**, найдвартай байдлын утга **0.924**, дундаж утгын үр дүн **0.581** тус тус гарсан. Эндээс сургалт ба хөгжил дундажаас бага үзүүлэлттэй, Асуулт-2:

“Давтан сургалт” **0.649**, Асуулт-4: “Практик сургалт” **0.467** ач холбогдлоор шаардлагад нийцэх байдлаар нь үнэлэх асуултын хариултын үр дүнгүүд хүлээлтээс бага түвшинд байгаа нь анхаарал татаж байна (Хүснэгт №6).

Хүснэгт №6. Хэмжил зүйн шинжилгээ (Сургалт, хөгжил)

Хувьсагч	Далд хувьсагч	Хэмжил зүйн утга	Кронбах альфа утга	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Сургалт, хөгжил	tr.dt-1	0.751	0.907	0.924	0.581
	tr.dt-2	0.649			
	tr.dt-3	0.756			
	tr.dt-4	0.467			
	tr.dt-5	0.887			
	tr.dt-6	0.835			
	tr.dt-7	0.813			
	tr.dt-8	0.812			
	tr.dt-9	0.808			

Хэмжил зүйн шинжилгээнээс харахад, зан төлөв нь **0.730-0.924** хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга **0.941**, найдвартай байдлын утга **0.950**,

дундаж утгын үр дүн **0.703** тус тус хувьсагчийн утгууд найдвартай байгааг баталсан (Хүснэгт №7).

Хүснэгт №7. Хэмжил зүйн шинжилгээ (зан төлөв)

Хувьсагч	Далд хувьсагч	Хэмжил зүйн утга	Кронбах альфа утга	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Зан төлөв	bhvr-1	0.730	0.941	0.950	0.703
	bhvr-2	0.827			
	bhvr-3	0.765			
	bhvr-4	0.882			
	bhvr-5	0.804			
	bhvr-6	0.924			
	bhvr-7	0.875			
	bhvr-8	0.882			

Хэмжил зүйн шинжилгээнээс харахад, оролцоо хувьсагч нь **0.670-0.855** хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга **0.904**, найдвартай байдлын утга **0.923**, дундаж утгын үр дүн **0.602** тус тус гарсан. Эндээс оролцоо хувьсагчийн бага

үзүүлэлттэй, Асуулт-1: “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн оролцоо” **0.670** нөлөөллөөр нь үнэлэх асуултын хариултын үр дүн хүлээлтээс бага түвшинд байгаа нь анхаарал татаж байна (Хүснэгт №8).

Хүснэгт №8 Хэмжил зүйн шинжилгээ (оролцоо)

Хувьсагч	Далд хувьсагч	Хэмжил зүйн утга	Кронбах альфа утга	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Оролцоо	engt-1	0.670	0.904	0.923	0.602
	engt-2	0.818			
	engt-3	0.847			
	engt-4	0.749			
	engt-5	0.783			
	engt-6	0.855			
	engt-7	0.729			
	engt-8	0.738			

Хэмжил зүйн шинжилгээнээс харахад, ажлын гүйцэтгэл хувьсагч нь **0.395-0.791** хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга **0.856**, найдвартай байдлын утга **0.887**, дундаж утгын үр дүн **0.448** тус тус гарсан. Эндээс ажлын гүйцэтгэл хувьсагчийн бага үзүүлэлттэй, Асуулт-1: “Мэргэжлийн үр чадвар” **0.486**, Асуулт-2:

“Мэргэжлийн зан төлөв” **0.654**, Асуулт-3: “сэтгэл ханамж” **0.395**, Асуулт-4: “сургалтын өгөөж” **0.692**, Асуулт-6: “шинжилгээний арга зүй” **0.666**, Асуулт-7: “ажлын үр дүн” **0.599** нөлөөллөөр нь үнэлэх асуултын хариултын үр дүнгүүд хүлээлтээс бага түвшинд байгаа нь анхаарал татаж байна (Хүснэгт №9).

Хүснэгт №9. Хэмжил зүйн шинжилгээ (ажлын гүйцэтгэл)

Хувьсагч	Далд хувьсагч	Хэмжил зүйн утга	Кронбах альфа утга	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Ажлын гүйцэтгэл	JBPRC-1	0.486	0.856	0.887	0.448
	JBPRC-2	0.654			
	JBPRC-3	0.395			
	JBPRC-4	0.692			
	JBPRC-5	0.783			
	JBPRC-6	0.666			
	JBPRC-7	0.599			
	JBPRC-8	0.773			
	JBPRC-9	0.791			
	JBPRC-10	0.735			

Харин гэмт хэргийн газрын үзлэг хийхэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгааны хувьд далд хувьсагчдын хүчин зүйлийн болон хамаарлын шинжилгээг 8 хувьсагчаар 7 замаар таамаглал дэвшүүлэн батлах оролдлогоор шинжилгээ хийсэн.

“Мэдлэг”-ийг 8 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.404-0.676** хооронд хэлбэлзэж байна. Мэдлэгийг үнэлэх бүх асуултын хариултын үр дүн хүлээлтээс бага төвшинд байгааг илтгэв. Мэдлэгийн кронпах альфа утгын үр дүн **0.728**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.799** байгаа нь манай судалгааны ажлын

үр дүн энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Гэвч дундаж утгын хувьд **0.338** байгаа нь нийт 8 далд хувьсагчийн үр дүн 0,7 тоон утгад хүрэхгүй байгаатай холбоотой. Асуулт бүрээс харьцуулахад асуулт-3 “Техник технологи ашиглах мэдлэг”, асуулт-4 “Шинжлэх ухааны суурь мэдлэг” хамгийн өндөр утгатай байсан бол асуулт-2 “мэргэжлийн тусгай мэдлэг”, асуулт-6 “гадаад хэлний мэдлэг, хэрэглээ” хамгийн бага утгатай байгаа нь илүү анхаарал татаж байна. Анхаарал татаж буй далд хувьсагчид практикт ажлын гүйцэтгэлд мэргэжлийн тусгай мэдлэг, гадаад хэлний мэдлэг, хэрэглээ нь нөлөөлөхдөө хангалтгүй байгаатай холбоотой гэж дүгнэх боломжтой.

Хүснэгт №10. Хэмжил зүйн шинжилгээ
(мэдлэг)

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
Мэдлэг	Кп-1	0.611	0.728	0.799	0.338
	Кп-2	0.404			
	Кп-3	0.662			
	Кп-4	0.676			
	Кп-5	0.622			
	Кп-6	0.426			
	Кп-7	0.572			
	Кп-8	0.611			

“Ур чадвар”-ийг 8 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.505-0.817** хооронд хэлбэлзэж байна. Ур чадварын кронпа альфа утгын үр дүн **0.852**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.884** байгаа нь судалгааны ажлын үр дүнд энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Гэвч дундаж утгын хувьд **0.493** байгаа нь нийт 8 далд хувьсагчаас 3 далд хувьсагч 0,7 гэсэн тоон утгад хүрэхгүй байгаатай

холбоотой. Асуулт бүрээс харьцуулахад асуулт-7 “оновчтой шийдвэр гаргалт”, асуулт-4 “багаар ажиллах ур чадвар” хамгийн өндөр утгатай буюу дээрх ур чадварууд сайн байгааг илтгэж байна. Харин Асуулт:1 “Мэргэжлийн ур чадвар” 0.505, Асуулт:6 “Ажиглах ур чадвар” 0.687, Асуулт:8 “Бусдад зөвлөх, чиглүүлэх чадвар” 0.543 тус тус гарч байгаа нь бусад чадвартай харьцуулахад уг чадварууд бага байгааг илтгэж байна(Хүснэгт №11).

Хүснэгт №11. Хэмжил зүйн шинжилгээ (ур чадвар)

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
Ур чадвар	Sk-1	0.505	0.852	0.884	0.493
	Sk-2	0.743			
	Sk-3	0.732			
	Sk-4	0.780			
	Sk-5	0.747			
	Sk-6	0.687			
	Sk-7	0.817			
	Sk-8	0.543			

“Техник, хэрэгсэл”-ийг 8 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **-0.331-0.870** хооронд хэлбэлзэж байна. Техник хэрэгслийн кронпа альфа утгын үр дүн **0.889**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.878**; дундаж утгын хувьд **0.546** байгаа нь манай судалгааны ажлын үр дүнд энэ хувьсагч найдвартай болохыг баталж байна. Асуулт бүрээс харьцуулахад

асуулт-8 “Техник хэрэгслийн бэлэн байдал”, асуулт-1 “Техник хэрэгслийн хүрэлцээ” хамгийн өндөр утгатай буюу дээрх ур чадварууд сайн байгааг илтгэж байна. Харин Асуулт:5 “Техник хэрэгслийн аюулгүй байдал” 0.689, Асуулт:6 “Техник хэрэгслийн овор хэмжээ” -0.331, тус тус гарч байгаа нь техник хэрэгслийн аюулгүй байдал, овор хэмжээ хангалтгүй байгааг илтгэж байна(Хүснэгт №12).

Хүснэгт №12. Хэмжил зүйн шинжилгээ (техник, хэрэгсэл)

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
Техник, хэрэгсэл	Tech-1	0.827	0.889	0.878	0.546
	Tech-2	0.762			
	Tech-3	0.740			
	Tech-4	0.727			
	Tech-5	0.689			
	Tech-6	-0.331			
	Tech-7	0.829			
	Tech-8	0.870			

“Хандлага, төлөвшил”-ийг 8 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.580-0.808** хооронд хэлбэлзэж байна. Хандлага, төлөвшлийн кронпа альфа утгын үр дүн **0.852**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.885** байгаа нь судалгааны ажлын үр дүнд энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Гэвч дундаж утгын хувьд **0.493** байгаа нь нийт 8 далд хувьсагчаас 4 далд хувьсагч 0,7 гэсэн тоон утгад хүрэхгүй байгаатай холбоотой. Асуулт бүрээс харьцуулахад асуулт-7 “Өөртөө итгэлтэй

байж шуурхай ажиллах байдал”, асуулт-8 “шинжээчийн сэтгэл зүй” хамгийн өндөр утгатай буюу дээрх хандлага төлөвшил сайн байгааг илтгэж байна. Харин Асуулт:1 “Мэргэжлийн зөвлөх хандлага” 0.583, Асуулт:2 “Мэргэжлээ эзэмшсэн байдал” 0.621, Асуулт:5 “Хүний эрхийг дээдлэх хариуцлагатай байдал” 0.580, Асуулт:6 “Аливаа зүйлд шударга хандах байдал” 0.679 тус тус гарч байгаа нь бусад хандлага төлөвшилтэй харьцуулахад хангалтгүй байгааг илтгэж байна(Хүснэгт №13).

Хүснэгт №13. Хэмжил зүйн шинжилгээ (хандлага, төлөвшил)

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
Хандлага, төлөвшил	At-1	0.583	0.852	0.885	0.493
	At-2	0.621			
	At-3	0.764			
	At-4	0.748			
	At-5	0.580			
	At-6	0.679			
	At-7	0.808			
	At-8	0.791			

“Орчин, нөхцөл байдал”-ийг 8 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.236-0.867** хооронд хэлбэлзэж байна. Орчин, нөхцөл байдлын кронпа альфа утгын үр дүн **0.803**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.846** байгаа нь судалгааны ажлын үр дүнд энэ хувьсагч найдвартай болохыг

баталсан. Гэвч дундаж утгын хувьд **0.435** байгаа нь нийт 8 далд хувьсагчаас 4 далд хувьсагч 0,7 гэсэн тоон утгад хүрэхгүй байгаатай холбоотой. Асуулт бүрээс харьцуулахад асуулт-4 “Хэргийн газрын нөхцөл байдал, цар хүрээ”, асуулт 2 “хэргийн газрын хамгаалалт” хамгийн өндөр утгатай буюу дээрх орчин нөхцөл байдалд дасан зохицох байдал сайн

байгааг илтгэж байна. Харин Асуулт:1 “Цаг агаарын нөхцөл байдал” 0.563, Асуулт:5 “Хэргийн газар ажиллах хугацаа” 0.669, Асуулт:7 “Хохирлын хэмжээ” 0.325,

Асуулт:8 “Хөндлөнгийн нөлөөлөл” 0.236 тус тус гарч байгаа нь бусад нөхцөл байдалтай харьцуулахад бага нөлөөлж байгааг илтгэж байна(Хүснэгт №14).

Хүснэгт №14. Хэмжил зүйн шинжилгээ (орчин, нөхцөл байдал)

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
Орчин, нөхцөл байдал	En-1	0.563	0.803	0.846	0.435
	En-2	0.812			
	En-3	0.703			
	En-4	0.867			
	En-5	0.669			
	En-6	0.805			
	En-7	0.325			
	En-8	0.236			

“Сургалт”-ийг 8 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.622-0.802** хооронд хэлбэлзэж байна. Сургалтын кронпа альфа утгын үр дүн **0.872**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.897**; дундаж утгын хувьд **0.524** байгаа нь судалгааны ажлын үр дүнд энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Асуулт бүрээс харьцуулахад асуулт-4 “практик сургалт”, асуулт 5 “ажлын байран дээрх сургалт” хамгийн өндөр утгатай буюу дээрх

сургалтууд сайн байгааг илтгэж байна. Асуулт:1 “Мэргэшүүлэх богино хугацааны сургалт” 0.622, Асуулт:2 “Мэргэшүүлэх урт хугацааны сургалт” 0.691, Асуулт:6 “Ажлын байрнаас гадуурх сургалт” 0.641, Асуулт:8 “Хөгжүүлэх сургалтын хэрэгцээ хангах байдал” 0.696 тус тус гарч байгаа шинжээч мэргэжилтнийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангасан ажлын байрнаас гадуурх урт хугацааны сургалт шаардлагатай байгааг илтгэж байна(Хүснэгт №15).

Хүснэгт №15. Хэмжил зүйн шинжилгээ (сургалт)

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
Сургалт	Tr-1	0.622	0.872	0.897	0.524
	Tr-2	0.691			
	Tr-3	0.794			
	Tr-4	0.802			
	Tr-5	0.801			
	Tr-6	0.641			
	Tr-7	0.716			
	Tr-8	0.696			

“Сэтгэл ханамж”-ийг 8 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.625-0.864** хооронд хэлбэлзэж байна. Сэтгэл ханамжийн кронпа альфа утгын үр дүн **0.899**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.917**; дундаж утгын хувьд **0.581** байгаа нь судалгааны ажлын үр дүнд энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Асуулт бүрээс харьцуулахад асуулт-6

“ажлын ачаалал, тэнцвэртэй байдал”, асуулт 7 “ажиллах цаг төлөвлөлт” хамгийн өндөр утгатай буюу дээрх байдалд сэтгэл ханамжтай байгааг илтгэж байна. Харин Асуулт:1 “Албан тасалгаа, ажлын орчин” 0.625, Асуулт:4 “Удирдлагын арга барил, хандлага” 0.647 тус тус гарч байгаа нь хариултын үр дүн хүлээлтээс бага төвшинд буюу дээрх байдалд сэтгэл ханамжгүй байгааг илтгэж байна(Хүснэгт №16).

Хүснэгт №16. Хэмжил зүйн шинжилгээ (сэтгэл ханамж)

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
Сэтгэл ханамж	Sat-1	0.625	0.899	0.917	0.581
	Sat-2	0.783			
	Sat-3	0.759			
	Sat-4	0.647			
	Sat-5	0.801			
	Sat-6	0.864			
	Sat-7	0.843			
	Sat-8	0.744			

“Ажлын гүйцэтгэл”-ийг 10 асуултаар хэргийн газар үзлэг хийхэд хэрхэн нөлөөлөх шинжилгээг хийхэд далд хувьсагчийн үр дүн **0.269-0.811** хооронд хэлбэлзэж байна. Ажлын гүйцэтгэлийн кронпа альфа утгын үр дүн **0.8771**; нийлмэл найдвартай байдлын хувьд **0.897** байгаа нь судалгааны ажлын үр дүнд энэ хувьсагч найдвартай болохыг баталсан. Гэвч дундаж утгын хувьд **0.480** байгаа нь нийт 8 далд хувьсагчаас 4 далд хувьсагч 0,7 гэсэн тоон утгад хүрэхгүй байгаагаар холбоотой. Асуулт бүрээс харьцуулахад асуулт-3 “мэргэжлийн

онцлог, хандлага төлөвшил” асуулт 10 “сургалтын өгөөж, үр дүн” хамгийн өндөр утгатай буюу дээрх гүйцэтгэл сайн байгааг илтгэж байна. Харин Асуулт:1 “Хэргийн өнгө” 0.269, Асуулт:2 “Мэргэжлийн мэдлэг, ур чадвар” 0.688, Асуулт:4 “Хэргийн талаар авсан мэдээлэл, онцлог” 0.505, Асуулт:9 “Гүйцэтгэлийн үр дүнг бодитоор үнэлэх үнэлэмж” 0.653 тус тус гарч байгаа нь хамгийн бага утгатай буюу бусад гүйцэтгэлтэй харьцуулахад бага байгааг илтгэж байна(Хүснэгт №17).

Хүснэгт №17. Хэмжил зүйн шинжилгээ (ажлын гүйцэтгэл)

Хүчин зүйл	Далд хувьсагч	Үр дүн	Кронбах альфа	Найдвартай байдал	Дундаж
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	PER-1	0.269	0.871	0.897	0.480
	PER-2	0.688			
	PER-3	0.770			
	PER-4	0.505			
	PER-5	0.737			
	PER-6	0.759			
	PER-7	0.763			
	PER-8	0.791			
	PER-9	0.653			
	PER-10	0.811			

**Хүснэгт № 18. Таамаглал батлах замын шинжилгээний үр дүн
Шинжилгээ хийхэд нөлөөлөх хүчин зүйлс**

ТААМАГЛАЛ	Дундаж утга	Стандарт хазайлт	Т статистик	П үнэ цэнэ	Үр дүн
Мэргэжлийн ур чадвар -> Ажлын гүйцэтгэл	0.314	0.161	1.998	0.046	батлагдсан
Техник, тоног төхөөрөмж -> Ажлын гүйцэтгэл	0.080	0.174	0.669	0.503	батлагдаагүй
Сэтгэл ханамж-> Ажлын гүйцэтгэл	-0.009	0.146	0.407	0.685	батлагдаагүй
Сургалт хөгжил -> Ажлын гүйцэтгэл	-0.072	0.156	0.564	0.573	батлагдаагүй
Зан төлөв-> Ажлын гүйцэтгэл	0.214	0.257	0.542	0.558	батлагдаагүй
Оролцоо-> Ажлын гүйцэтгэл	0.520	0.194	3.146	0.002	батлагдсан

Хэргийн газрын үзлэг хийхэд нөлөөлөх хүчин зүйлс

ТААМАГЛАЛ	Дундаж утга	Стандарт хазайлт	Т статистик	П үнэ цэнэ	Үр дүн
Мэдлэг -> Ажлын гүйцэтгэл	-0.031	0.144	0.785	0.433	батлагдаагүй
Ур чадвар -> Ажлын гүйцэтгэл	0.129	0.139	1.103	0.270	батлагдаагүй
Техник, хэрэгсэл-> Ажлын гүйцэтгэл	-0.152	0.110	1.381	0.168	батлагдаагүй
Хандлага, төлөвшил -> Ажлын гүйцэтгэл	0.357	0.135	3.708	0.002	батлагдсан
Орчин, нөхцөл байдал -> Ажлын гүйцэтгэл	0.073	0.101	0.548	0.584	батлагдаагүй
Сургалт -> Ажлын гүйцэтгэл	0.259	0.094	2.783	0.006	батлагдсан
Сэтгэл ханамж -> Ажлын гүйцэтгэл	0.313	0.104	3.244	0.001	батлагдсан

Дүгнэлт

Криминалистикийн шинжээч үндсэн чиг үүргээ гүйцэтгэхэд тусгай мэдлэгээс гадна олон ур чадвар шаардагддаг бөгөөд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах болон гэмт хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцоход нөлөөлж буй хүчин зүйлс нь харилцан адилгүй байна. Тиймээс шинжилгээ хийхэд нөлөөлөх хүчийн зүйлийн судалгаагаар тэдний мэргэжлийн ур чадвар, мэргэжлийн туршлага, техник тоног төхөөрөмжийн хэрэглээ, оролцоо, зан төлөв, сэтгэл ханамж зэргийг нарийвчлан судласан. Уг судалгааны үр дүнгээс харахад, мэргэжлийн ур чадвар, оролцоо нь ажлын гүйцэтгэлд эерэгээр

нөлөөлж дэвшүүлсэн таамаглал батлагдсан.

Мэргэжлийн ур чадварын хувьд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлдөг нь батлагдсан хэдий ч “Шинжилгээний арга зүйн ашиглалт”, “Дүгнэлт бичих”, “Техник хэрэгсэл ашиглалт”, “Нарийвчлан ажиглах байдал”, “Шүүмжлэлт сэтгэлгээ”, “Мэргэжлийн туршлага” гэсэн далд хувьсагчид 0.7-оос доош гарсан. Үүний шалтгаан нь криминалистикийн шинжилгээний онцлогоос хамааран тухайн шинжилгээг хийж буй шинжээч сэтгэлгээний ур чадвар сайтай, шинжилгээний арга зүйг бүрэн эзэмшиж, ашигладаг байхаас гадна шинжилгээний

дүгнэлтэд хүрэх үндэслэлээ оновчтой тодорхойлж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах боломжтой боловч өнөөгийн практикт ажиллаж буй шинжээчдийн мэргэжлийн эдгээр ур чадвар дутмаг байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Мөн криминалистикийн шинжээчийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажлын гүйцэтгэлд зөвхөн шинжээч бус шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд, шинжилгээний байгууллагын удирдлага болон бүртгэлийн ажилтан зэрэг оролцогчдын оролцоо эерэг нөлөө үзүүлнэ хэмээн таамагласан ч “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн оролцоо” гэсэн далд хувьсагч 0.7-оос доош гарсан нь шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн мэдлэг, ур чадвар, шуурхай ажиллагаанд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Судалгааны таамаглалаас хүчин зүйлийн шууд хамаарлыг шинжлэхэд криминалистикийн шинжээчийн зан төлөв, техник, тоног төхөөрөмж, сургалт, хөгжлийн ихэнхи далд хувьсагч 0.7-оос дээш гарч үр дүн сайтай байсан ч шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлж чадахгүй байгаа нь батлагдсан.

Тухайлбал техник, тоног төхөөрөмжийн далд хувьсагчуудын ихэнх нь 0.7-оос дээш гарч техник, тоног төхөөрөмж ажлын гүйцэтгэлд тодорхой эерэг нөлөө үзүүлж байна гэж үзэж болох ч “Техник, тоног төхөөрөмжийн ашиглалт”, “Техник, тоног төхөөрөмжийн стандартчлал” гэсэн далд хувьсагчид 0.7-оос доош гарсан нь шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажлын гүйцэтгэлд эерэг нөлөө бий болгож чадахгүй байгааг батлав. Уг үр дүнгээс харахад криминалистикийн шинжилгээг зөвхөн уламжлалт аргаар бус шинээр техникт суурилсан шинжилгээний арга зүйг нэвтрүүлэх, олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийг ашиглах шаардлага үүсэж байна.

Харин гэмт хэргийн газрын үзлэг хийхэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаагаар мэдлэг, ур чадвар, техник хэрэгсэл, хандлага, төлөвшил, орчин, нөхцөл байдал, сургалт, сэтгэл ханамж зэргийг нарийвчлан судалсан.

Судалгаанаас харахад шинжээч, мэргэжилтэн гэмт хэргийн газар үзлэг хийхэд шууд нөлөөлөх хувьсагч буюу мэдлэг, ур чадвар, техник, хэрэгсэл, орчин, нөхцөл байдлын далд хувьсагчдад сөрөг үр дүнг илэрхийлэх асуудал ихээхэн агуулж байгааг илтгэж байна. Судалгааны таамаглалаас хүчин зүйлийн шууд хамаарлыг шинжлэхэд шууд хувьсагч болох мэдлэгийн бүх далд хувьсагч 0.7-оос доош гарсан нь мэдлэгийн түвшин ажлын гүйцэтгэлд хангалтгүй байгааг батлав. Мөн алба хаагчдын ур чадвар, ашиглаж буй техник хэрэгсэл, ажиллах орчин нөхцөл, байдлын зарим далд хувьсагчид эерэг үр дүнтэй байсан ч эдгээр нь ажлын гүйцэтгэлд хангалттай эерэг нөлөө үзүүлэхгүй байна гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл ажил олгогчийн зүгээс шинжээч, мэргэжилтний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах, гэмт хэргийн газрын үзлэг хийхэд шаардлагатай техник хэрэгслээр хангах, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа нь судалгааны үр дүнд батлагдсан.

Тиймээс төрөл бүрийн үр дүнтэй техник хэрэгслийг нэвтрүүлж, энэ чиглэлээр туршилт судалгаа хийх орчин нөхцөл, ажиллах боломжоор хангаж, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, улмаар байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг үр дүнтэй гүйцэтгэх боломжтой юм гэж дүгнэж байна.

Санал

Криминалистикийн шинжээчийн ажлын гүйцэтгэлийг сайжруулахын тулд мэргэшиж ажиллаж буй чиглэл(мөр судлал, гарын мөрийн шинжилгээ, хэргийн газрын үзлэг г.м) болон харъяалагддаг нэгж (Криминалистикийн шинжилгээний газар, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар эсхүл Аймгийн шүүхийн шинжилгээний алба г.м)-д нь тохирсон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна.

Эх сурвалж

Ном сурах бичиг

1.Жанцан, С. Хууль зүйн сэтгэл судлал. –Уб., 2005 он

2.Жаргалсайхан, Б. Учралын
газрын үзлэг. –Уб., 2008 он

3.Лхагвасүрэн, Б. Мөр. -Уб., 2015
он

4.Очирбат, Т. Соронзонболд, Ч.
Хэргийн газрын үзлэг. –Уб., 2012 он

5.ЦЕГ-Мөрдөн байцаах алба.
Хэргийн газрын үзлэгийн үндэс. –Уб.,
2013 он

Эрдэм шинжилгээний бүтээл

1.Pandey, J. (2019), "Factors
affecting job performance: an integrative
review of literature", Management Research
Review, Vol. 42 No. 2

2.Bader Alyoubi, Rakibul Hoque,
Ibraheem Alharbi, Adel Alyoubi, Najah
Almazmomi. (2018), "Impact of Knowledge
Management on Employee Work
Performance: Evidence from Saudi Arabia",
The International Technology Management
Review, Vol. 7, No. 1

3.Hassan M. E. Aboazoum, U.
Nimran, M. A. Musadieq. (2015), Analysis

Factors Affecting Employees Job
Performance in Libya,

4.Maureen Mwaiko. (2013), Factors
affecting employee performance
Assessment in the education sector in
Tanzania: a Case study of Pugu secondary
school,

5.Li Wang, Kunhui Ye, Yu
Liu, Wenjing Wang (2022) Factors affecting
expert performance in bid evaluation: An
integrated approach,

6.Tengpongsthorn, W. (2016)
Factors affecting the effectiveness of police
performance in Metropolitan Police Bureau

Цахим хуудас

1.[https://mn.wikipedia.org/
performance-management](https://mn.wikipedia.org/performance-management)

2.<https://www.emerald.com/>

3.[https://trainingindustry.com/articles/
performance-management](https://trainingindustry.com/articles/performance-management)

4.[https://www.digital-
adoption.com/employee-performance/](https://www.digital-adoption.com/employee-performance/)